

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА, ОНЦЛОГ ШИНЖ

SOCIAL GUARANTEE AND DISHTINCTNESS OF POLICE PERSONNELS

**Н.ЛХАГВАСАЙХАН**

ХСИС-ийн докторант, цагдаагийн дэд хурандаа

LKHAGVASAIKHAN N.

Doctoral candidate at the Law Enforcement University, Police Lieutenant Colonel

Товч агуулга: Цагдаагийн алба хаагч нь төрийн тусгай албан тушаалд томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагч тул нэг талаас хүний эрх, эрх чөлөөг бусад хүмүүсийн адил эдлэх, баталгааг бүрдүүлэхийг төрөөс шаардах эрхтэй, нөгөө талаас төрийн албан хаагч тул иргэнээс ялгагдах онцлогтойгоор нийгмийн хамгаалалд хамрагдах, баталгаагаар хангагдах боломжтой байдаг.

Цагдаагийн алба хаагчийн эрхийг хангах нийгмийн баталгааны тухай ойлголт нь өргөн утгаараа, хүний эрхийг хангах, явцуу утгаараа төрийн тусгай алба хаагчийн бүр нарийвчилбал, цагдаагийн алба хаагчийн албаны үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх үйл ажиллагаатай уялдаатай яригдах асуудал юм.

Abstract: State police officer appointed to positions as public servants, on the one hand, they have human rights, they have the right to enjoy free life like other civilians. Moreover, they have the right to require the government to provide a guarantee. On the other hand, civil servants, so distinguish individuals covered by social protection and guarantees can be provided.

In a broad sense, concept of social guarantee to ensure the rights of police officers is related to human rights, narrowly special state of official and even complexity according to police official exercise the rights and fulfill their duties is a matter related to the activities.

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааны тухай асуудал нь агуулга, зарчим, мөн чанарын хувьд хүний эрхийн нийгмийн баталгаа гэсэн ойлголттой нийтлэг талтай буюу нэг хэсэг нь гэж хэлж болно. Иймд хүний эрхийн нийгмийн баталгааны тухай асуудлыг товч авч үзье.

“Баталгаа” гэдэг нь хэл зүйн агуулга талаасаа:

1. Ямар нэг үйл явдлын үнэн магадыг нотлох бичиг баримт, тэмдэг: баримт баталгаа, баталгаа тэмдэг, баталгаа гаргах (батлах, бичиг баримт бичиж өгөх)

2. Нотлох бичиг баримт бүхий: баталгаатай бичиг, баталгаатай захидал (шуудангийн газраас тухайн эзэнд нь заавал хүргэж өгөхийг хариуцаж авсан албан бичиг буюу захидал)¹ гэсэн агуулгаар тайлбарладаг.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө гэсэн II бүлэгт хүний жам ёсны заяагдмал эрхийг тунхаглан хуульчлав. Эдгээрийн дотор хүний нийгмийн хамгааллын эрх тодорхой байр суурийг эзлэх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 16

¹ И.Дамбажав. Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан Монгол үгийн дээж. УБ., 2010.



дугаар зүйлийн 16.5-д өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэйг, 16.6-д эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэйг болохыг² тус тус хуульчлан тогтоож баталгаажуулсан байна.

Хүний эдлэх нийгэмшлийн эрхийг зөвхөн хуулиар тогтоох нь хангалтгүй бөгөөд түүний хэрэгжилтийг хангах баталгааг тогтоох буюу хэрэгжих бодит нөхцөл байдлыг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоон бататгасан хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх үүргийг төр хүлээдэг.

Энэ тухай Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэн, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”³ гэжээ.

Судлаачид хүний эрхийн баталгааны тухай асуудлыг чухалчлан авч үзсэн байдаг. “Хүний эрхийг хуулиар тунхаглаад зогсохгүй тэдгээрийг хэрэгжүүлэх бодит нөхцөл бололцоогоор хангах ёстой. Үндсэн хуульд зааснаар хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг төр хүлээдэг.

Нийгмийн баталгаа гэдэг нь хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх нийгмийн боломж, нөхцөл бүрдүүлэхийг ойлгоно гэжээ⁴.

Мөн хүний эрх, эрх чөлөөг хуульчлан зааснаар аяндаа хэрэгжихгүй, иймд төрөөс тэдгээрийг хэрэгжүүлэх бодит нөхцөл бололцоогоор хангах, үүний тулд юуны өмнө эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх механизмыг тогтоох учиртай... Засаг төр, төрийн албан тушаалтны үйл ажиллагаа нь бүхэлдээ хүний төлөө, хүний эрх,

эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг баталгаатай хангах нөхцөл бололцоог бий болгоход чиглэгдэж байх нь Үндсэн хуулийн чухал шаардлага юм. Хүний эрх, эрх чөлөөг хангах талаар төрийн хүлээх үүрэг нь:

- Хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх

- Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх

- Хүний эрхийг хуулиас гадуур хязгаарлах бүхий л тохиолдлыг таслан зогсоох, хүний нэр төр, алдар хүнд, ашиг сонирхлыг хүндэтгэх, түүнийг хамгаалах үр нөлөөтэй арга хэмжээ авах замаар хэрэгжинэ.

Эрх, эрх чөлөөг амьдралд тууштай хэрэгжүүлэх, сахин хамгаалах нөхцөл, хэлбэр, аргын нийлбэрийг тэдгээрийн баталгаа гэнэ. Нийгмийн баталгаа гэдэг нь хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх нийгмийн боломж нөхцөлийг бүрдүүлэхийг хэлнэ⁵ гэсэн байна.

Судлаач Б.Нармандах “Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй бүтээл”-дээ хүний эрхийг хангах баталгаа гэдэг нь, хуульчлан тодорхойлсон эрхийг үнэн бодитой хэрэгжүүлэх нөхцөл, боломжийг хангахад чиглэгдсэн нийгэм, эдийн засаг, улс төр, үзэл суртал, хууль зүйн цогц асуудлыг хамтатгасан нийгмийн шинжтэй асуудал юм... Нийгмийн баталгаа гэдэг нь хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх явдал юм⁶ гэж үзсэн байна.

Эрдэмтэн, судлаачдын хамтын бүтээл болох Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар номд “Үндсэн хуульд болон Монгол улсын олон улсын гэрээгээр тунхаглан хуульчилсан хүний эрхийг төрийн зүгээс санаатай буюу болгоомжгүй аль нэг хэлбэрээр зөрчих нь зөвхөн ганц нэг хүний эрхэнд халдаад зогсохгүй нийтийг хамарсан зөрчилд

² Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. 8 дах тал

³ Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992. 11 дах тал

⁴ Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. 107, 108 дах тал.

⁵ Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007. 138-139 дэх тал.

⁶ Б.Нармандах. Үндсэн хуулийн эрх зүй. УБ.



хүргэх ноцтой хор хохирол учруулдаг тул түүнээс урьдчилан сэргийлэх нь ардчилсан төрийн үйл ажиллагааны нэг үндсэн чиг үүрэг түүний хүмүүнлэгийн гол агуулгыг илэрхийлдэг. Учир иймд, хүний эрх, эрх чөлөөний бүх талын баталгааг бүрдүүлэх үндсэн механизмыг тогтоох явдал бол, хүний эрхийн салбар дах төрийн бодлогын гол цөм байх учиртай... төр засгаас иргэдийн эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэх, соёл боловсрол, урлаг, спорт, жуулчлалыг хөгжүүлэх, эрүүл ахуй, нийгмийн хангамж, хамгаалалт, орон сууц зэрэг аж амьдралын амин чухал асуудлыг нийгмийн бодлогынхоо дээд хууль болгосноор хүний эрхийн нийгмийн баталгааг хангах болно.

Хүний эрхийн баталгааг бүрдүүлэх бусад асуудал гэдэгт, төрөөс нийгмийн амьдралыг боловсронгуй болгох удирдлага, зохион байгуулалтын асуудлууд хамаарна⁷. Хүний эрхийг хангах баталгааг тогтоох төрийн үүрэг, түүний дотор нийгмийн баталгааг бүрдүүлэх чиглэлийн тодорхой арга жэмжээг дурдсан байна.

Хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг төр бүрдүүлэх энэ үүргээ биелүүлээгүй бол иргэн шаардах эрхээ эдлэх боломжтойг мөн иргэн, төрийн эрх, үүргийн харилцан шүтэлцээ, хүний эрх, эрх чөлөө эрх зүйт төрийн салшгүй зарчим болох тул түүнийг дээдлэн хангах, хэрэгжих баталгааг нь бүрдүүлэх шаардлагатайг зарим бүтээлд⁸ тусгасан байна.

Гавьяат хуульч, доктор, профессор Г.Совд Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх бүтээлдээ хүний эрхийн хэрэгжилтийг хангах нийтлэг, тусгай, олон улсын механизм гэсэн тогтолцоо байдгийг нэг бүрчлэн авч үзсэн байна. Нийтлэг механизм нь хүний эрх, эрх чөлөөг хангах ерөнхий зарчмыг, тусгай гэдэг нь, тодорхой үйл ажиллагааны хүрээнд Тухайлбал, эрүүгийн байцаан

шийтгэх ажиллагааны үед эдлэх хүний эрхийг хамгаалах нөхцөл, арга, хэлбэрийг хамааруулж үзнэ.

Хүний нийгэмшлийн эрхийн асуудал нь, нэг улс орны хүрээнээс хальж олон улсын эрх зүйн зохицуулалт хамгаалалтад тусгагдсан байдаг.

Хүний эрхийн тухай түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай факт, Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын факт, Тахир дутуу хүмүүсийн эрхийн тухай конвенц, Оюуны хомсдолтой хүмүүсийн эрхийн тухай конвенц зэрэг олон улсын баримт бичгүүдээр хүний нийгэмшлийн эрхийг хамгаалж бататгасан байдаг.

Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 22 дугаар зүйлд “Хүн бүр нийгмийн гишүүний хувьд нийгмээс хангамж авах эрхтэй бөгөөд нэр төрөө хамгаалах, биеэ боловсруулж хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай эдийн засаг, нийгэм соёлын талын эрх дархаа тухайн орны хүчин чармайлт хийгээд олон улсын хамтын ажиллагааны нөөц бололцоонд нийцүүлэн эдлэх эрхтэй”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ, сувилгаа нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй, ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсвэл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй”⁹ гэсэн нь хүний салшгүй эрхийн дотор нийгмийн хамгааллын хүрээнд эдлэх эрх тодорхой байр суурийг эзлэх бөгөөд энэхүү эрхийг үндэсний хууль тогтоомждоо тусган бататгаж хэрэгжилтийг нь хангах баталгааг бүрдүүлэх шаардлагыг НҮБ-ын гишүүн орон бүрийн төрд тавьж байгаа хэрэг юм.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын фактын 9 дүгээр зүйлд “Энэхүү фактад оролцогч

⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000. 134 дэх тал.

⁸ Д.Солонго, Ш.Үнэнтөгс, С.Энхжаргал, С. Эрдэнэболор. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007. 136 дах тал.

⁹ Хүний эрх. Олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ., 1998. 7 дахь тал.



улсууд нийгмийн зааглалыг оролцуулан хүн бүрийн нийгэм, хангамжийн эрхийг хүлээн зөвшөөрнө", 11 дүгээр зүйлийн 1-д "Энэхүү фактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний гэр бүлийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас хунар, орон сууцыг оролцуулан амьдралын хүрэлцээтэй түвшинд амьдрах, амьдралынхаа нөхцөлийг байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрнө"¹⁰ гэсэн нь хүн бүр ямар нэг ялгаваргүйгээр нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамрагдах, нийгмийн хангамжийг хүртэх эрхийг нь олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч зохицуулсан зохицуулалт юм.

Хүний нийгэмшлийн (нийгэм хангамжийн) хүрээнд эдлэх эрхийг хангах төрийн үүрэг нь нийгмийн хамгааллын арга хэмжээгээр дамжин хэрэгжиж байдаг. Өөрөөр хэлбэл төрийн нийгмийн хамгааллын бодлого, чиглэл, үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт нь бүхэлдээ хүний нийгэмшлийн эрхийг хангах баталгааг бүрдүүлж байгаа хэрэг болно.

Нийгмийн хамгаалал ямагт хүнд чиглэгдэн явагддаг. Улс орон бүр өөрийн эдийн засгийн хөгжил, амьдралын баталгаат түвшний үзүүлэлтээс хамаарч хүн оршин амьдрах нөхцөлд харшлах, алдагдуулах нөхцөл шалтгааныг тогтоох, гэхдээ өөрийн орны нийгэм, эдийн засгийн хөгжил, нөхцөл байдалтай уялдуулан авч үзсээр иржээ.

Хүнийг нийгмийн хамгаалалд авах, нийгмийн хамгааллын эрхийн баталгааг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага нь тэдэнд жам ёсны болон нийгмийн зүгээс учруулдаг бусад эрсдэлтэй холбоотой байдаг.

Уг эрсдэлд байгалийн жамаар бий болох буюу өтлөх, хүүхэд төрүүлэх, нас барах, насанд хүрээгүй хүний асран хамгаалалтын асуудлууд, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай холбогдсон буюу тухайлбал, ажилгүйдэл, ядуурал гэх зэрэг эрсдэлүүд хамаарна.

¹⁰ Хүний эрх. Олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл. УБ., 1998. 37,38 дахь тал.

Эдгээр эрсдэлийг зөв тодорхойлж чадсанаар урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгахад чиглэсэн төрийн бодлого чиглэл оновчтой болж нийгмийн хамгааллын тогтолцоо баталгаатай, найдвартай байх нөхцөл бүрддэг.

Иймээс нийгмийн хамгаалал гэсэн ойлголт нь хүн өтлөх, осол гэмтэлд өртөх, өвчлөх, хөдөлмөрийн чадвараа алдах зэргээр хэвийн байдлаар амьдрах нөхцөл алдагдахад төрийн зүгээс амьдралын наад захын баталгааг бүрдүүлэх үүднээс төрийн зүгээс асрамжлах, халамжлах, тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох харилцаа юм.

Гэхдээ, үүнийг зөвхөн нийгмийн даатгал, нийгмийн халамж, нийгмийн эмзэг хэсэгт үзүүлэх үйлчилгээ гэсэн ойлголтоор хязгаарлаж болохгүй бөгөөд бүх нийтийн эрүүл мэнд, эрүүл орчин ахуйг бүрдүүлэх, экологийн тэнцвэрт байдлын ойлголт ч хамаарах юм.

Нийгмийн хамгаалал нь эдийн засаг, нийгэм, эрх зүйн шинжийг өөртөө агуулж байдаг. Нийгмийн орлогын дахин хуваарилалт хийх, нийгмийн хамгааллыг хэрэгжүүлэх зохион байгуулалт - эрх зүйн арга хэм хэмжээний тусламжтай бий болгох зэргээр удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаанууд нь ихэнхдээ эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг. Нийгмийн хамгааллын үйл ажиллагааг зохицуулж, хүний нийгмийн хамгааллын хүрээнд эдлэх эрхийн баталгааг бүрдүүлсэн цөөнгүй хууль Монгол Улсад үйлчилж байна. Тухайлбал, Нийгмийн даатгалын багц хууль, Нийгмийн халамжийн багц хууль, Төрийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиудыг дурдаж болно. Эдгээрээс "Төрийн албаны тухай хууль", "Цэргийн алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль"-иар цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг хангах үндэслэл, нөхцөл байдлуудыг тогтоож зохицуулсан байдаг.

Хүмүүсийн орлогын тэнцвэргүй



байдал, амьжиргааны түвшингийн **ялгаа**, хөдөлмөрийн ялгаатай байдлыг зохицуулахдаа төрөөс эдийн засгийн аргуудыг хэрэглэдэг бөгөөд энэ нь түүний эдийн засгийн шинж чанарыг илэрхийлнэ.

Хамгаалал нь, хувь хүнд хүрэхдээ түүний онцлог, ялгагдах байдлыг харгалздаг хэдий ч хүний эрхийг хамгаалах баталгаа болдгоороо нийгмийн шинж чанар нь илэрдэг.

Төрийн нийгмийн хамгааллын арга хэмжээ нь эдийн засгийн, улс төрийн, нийгмийн, хүн ам зүйн чиг үүргийг гүйцэтгэдэг. Эдгээрээс нийгмийн чиг үүргийг хүний амьдрах болон бусад нийгэмшлийн эрхийг хангах баталгаа нь болдог ба хүн эрсдэлд өртөн хөдөлмөрийн чадвараа алдах, өтлөх, ажилгүйдэл, ядууралд өртөх, хүүхэд төрүүлэх болон асрах зэрэг хамгаалал авах зайлшгүй шаардлагатай нөхцөл байдал (тохиолдол) болсон үед тэтгэвэр, тэтгэмж, тусламж олгох, үйлчилгээ үзүүлэх зэрэг хэлбэрээр дэмжлэг үзүүлж, бусад иргэдийн адил амьдрах хөдөлмөрлөх нөхцөлийг нь бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа ч гэж ойлгож болно.

Аливаа улс орны хувьд нийгмийн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх нь төр иргэнийхээ (хүний) өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаагийн нэг чухал илрэл гэж үздэг бөгөөд амьдрах, хөдөлмөрлөх эрхийг нь хангах баталгаа болдог учраас магадгүй хүний бусад эрхүүдийн дотор нилээд голлох байр суурийг эзлэх асуудал юм.

Улс орнуудын нийгэм, эдийн засгийн байдлаас хамааралтайгаар хүнийг нийгмийн хамгаалалд авах асуудал, нийгмийн хамгааллын арга хэмжээний төрөл, хамрах хүрээ, ялгаатай байх хэдий ч дараах зарчмын шинжтэй асуудал, аль ч орны нийгмийн хамгааллын хувьд адил төсөөтэй байдаг нь ажиглагдаж байлаа. Үүнд:

1. Нийгмийн бүтээгдэхүүн, хуримтлалыг хуваарилах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг төрөөс тогтоох байдлаар нийгмийн

хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлдэг, Нийгмийн даатгалын хувьд хуримтлалын, хагас хуримтлалын, хуваарилалтын тогтолцоог ашигладаг байна.

Монгол Улсын хувьд татварын орлогоор төвлөрсөн төсвийг хуваарилалтын аргаар нийгмийн хангамжийн арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт үйлчилж байна. Нийгмийн эмзэг хэсэгт хамрагдах иргэдэд тэтгэвэр, тэтгэмж тусламж олгох үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ, түүнчлэн нийгмийн даатгалын санд шимтгэл төлсөн иргэдэд хагас хуримтлалын зарчмаар тэтгэвэр, тэтгэмж, бусад төлбөрийг олгох арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүй, удирдлага, зохион байгуулалтыг төрөөс тогтоосон нь хүний эрхийг хангах нийгмийн баталгааг зохих хэмжээнд бүрдүүлсэн хэрэг юм.

2. Нийгмийн гишүүдийн амьжиргааны түвшин, ажилгүйдэл, ядуурлын индекс, түүнчлэн нийгмийн халамж, даатгалын арга хэмжээнд хамрагдагсад олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үзүүлэх үйлчилгээний байдал, эдгээрийн төрөл, хэмжээ, хугацааг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагын судалгаа, дүгнэлтэд үндэслэн төр нь, нийгмээс хамааралтай эрсдэлийг тооцон тогтоож, түүний мөрөөр нийгмийн хамгааллын боломжит арга хэмжээг авахад анхаарал хандуулдаг.

3. Төр нь нийгмээс хамааралтай эрсдэлд өртөх магадлалтай болон өртсөн хүмүүсийн талаар бодитой судалгаанд үндэслэн нийгмийн хамгаалалд хамрагдах шаардлагатай хүмүүсийн хүрээг тогтоох.

4. Тусламж, дэмжлэгийн төрөл, олгох нөхцөл, хэмжээг тодорхойлох журмаар нийгмийн хамгааллын стандартыг тогтоох асуудлуудад голлон анхаарч төрийн эрх мэдлийн хүрээнд зохих арга хэмжээг авдаг байна.



Цагдаагийн алба хаагч нь төрийн тусгай албан тушаалд томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагч тул нэг талаас хүний эрх, эрх чөлөөг бусад хүмүүсийн адил эдлэх, баталгааг бүрдүүлэхийг төрөөс шаардах эрх эдлэх, нөгөө талаас төрийн албан хаагч тул иргэнээс ялгагдах онцлогтойгоор нийгмийн хамгаалалд хамрагдах, баталгаагаар хангагдах боломжтой байдаг.

Иргэнийг цагдаагийн алба хаагчаар тооцох үндэслэл бүрдсэн үеэс, төрийн тусгай албан хаагчийн хувьд төрийн хамгаалалтад багтах албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх, эрхээ эдлэхтэй холбогдох баталгааг бүрдүүлэхийг төрөөс шаардах эрх нь үүсдэг.

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаа гэдэг нь, цагдаагийн алба хаагчийн эрхийг үүний дотор нийгмийн хамгааллын хүрээнд эдлэх эрхийг хангахад чиглэгдсэн эдийн засаг, эрх зүй, нийгмийн шинжтэй арга хэмжээний цогц ойлголт юм.

Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааны асуудлыг тусгайлан судалсан бүтээл байхгүй бөгөөд хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Долгорсүрэн Монгол Улсын Цагдаагийн эрх зүй¹¹, хууль зүйн ухааны доктор, профессор Д.Таванжин Монгол Улсын Цагдаагийн лавлах толь¹², Монгол Улсын Цагдаагийн эрх зүй¹³ бүтээлдээ авч үзсэн байна.

Судлаачид бүтээлдээ цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг хангах эрх зүйн хамгаалалт болох тэтгэвэр, тэтгэмж, тусламж үзүүлэх талаар холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтуудыг тусгажээ.

Цагдаагийн алба хаагчийн эрхийг хангах нийгмийн баталгааны тухай ойлголт нь өргөн утгаараа, хүний эрхийг хангах, явцуу утгаараа төрийн тусгай

алба хаагчийн бүр нарийвчилбал, цагдаагийн алба хаагчийн албаны үүргээ биелүүлэх, эрхээ эдлэх үйл ажиллагаатай уялдаатай яригдах асуудал юм.

Төрөөс хүний нийгмийн хүрээнд эдлэх эрх түүний баталгааг хангах асуудлын дотор цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааны асуудал зохих байр суурийг эзэлдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө гэсэн II бүлэгт хуульчлан тогтоосон хүний эрх, түүнийг хангах баталгааг бүрдүүлэх төрийн үүргийн талаарх холбогдох заалтууд нь цагдаагийн алба хаагчид ч нэг адил хамааралтай тул нийгмийн хамгааллын хүрээнд эдлэх хүний эрх, эрх чөлөө, түүнийг бататган хамгаалах нийтлэг арга хэмжээний мөн чанар, зорилго, зарчим цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг тогтооход ч адил байна.

Төрөөс тогтоодог хүний нийгэмшлийн эрхийг хангах баталгаатай, цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгааг харьцуулахад дараах нийтлэг тал болон ялгагдах онцлогтой байна.

Нийтлэг тал.

1. Нийгмийн баталгааг бүрдүүлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл чиг үүрэг нь болдог. Төрийн үүргийг Монгол Улсын Үндсэн хуульд болон холбогдох бусад эрхийн актуудад тусгасан байна.

2. Нийгмийн зүгээс учрах аливаа эрсдэлээс хамгаалах, эрсдэлд өртсөн тохиолдолд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

3. Хүний болон цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдлын нийгмийн баталгаа нь эдийн засаг, эрх зүйн болон нийгмийн шинжтэй байдгаараа адил талтай. Цагдаагийн алба хаагчид тэтгэвэр, тэтгэмж, тусламж олгох, нийгмийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ нь мөн л татвар төлөгчдийн төлсөн татварын хуримталлыг хуваарилахтай холбогдох эдийн засгийн олон арга, хэлбэрээр дамжин хэрэгждэг. Мөн түүнд нийгмийн хангамж эдлүүлэхтэй холбогдох харилцаа нь Монгол Улсын

¹¹ Ж.Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ., 2000. 138-140 дэх тал.

¹² Д.Таванжин. Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн лавлах толь. УБ., 2008. 187-189 дэх тал.

¹³ Д.Таванжин. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ., 2006. 257-261 дэх тал.

“Төрийн албаны тухай хууль”, “Цагдаагийн байгууллагын тухайн хууль”, “Цэргийн алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль” болон холбогдох бусад хууль эрхийн актуудаар зохицуулагддаг.

4.Нийгэмшлийн эрхийг нь хангах баталгааг бүрдүүлэхийг төрөөс шаардах эрхийг “иргэн” (хүн) “Цагдаагийн алба хаагч” адил эдэлнэ.

5.Цагдаагийн алба хаагч болон бусад иргэнд үзүүлэх нийгмийн даатгал, халамжийн төрөл, ихэнхдээ адил байдаг.

д/д	Нийгмийн хамгааллын арга хэмжээний төрөл	Хамрагдах байдал	
		Иргэн /хүн/	Цагдаагийн алба хаагч
1	Тэтгэвэр	+	+
2	Тэтгэмж	+	+
3	Тусламж	+	+
4	Үйлчилгээ	+	+
5	Төлбөр, зардал	+	+

Ялгагдах онцлог

•Цагдаагийн алба хаагчийн нийгмийн баталгаа нь, түүний албаны үүрэг, эрх мэдлийг хэрэгжүүлж хангахтай холбоотой байдаг тул эрх зүйн зохицуулалтын хувьд тусгай хууль, эрхийн актуудаар зохицуулах шаардлагыг бий болгодог. Тухайлбал, Цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль гэх зэрэг.

•Цагдаагийн алба хаагчийн ажил үүргийн онцлогтой холбоотойгоор тэтгэвэр, тэтгэмжийг олгох үндэслэл, хэмжээ болон нэмэгдэл баталгаагаар хангагдах боломж, иргэнтэй харьцуулахад давуу талтай байдаг.

•Төрийн үйлчилгээний алба хаагчид болон бусад иргэнтэй харьцуулахад эрсдэлээс хамгаалахаар төвлөрүүлсэн тусгай мөнгөн хөрөнгийн санд (даатгалын сан) шимтгэл төлөх үүргийг цагдаагийн алба хаагчийн өмнөөс төр хариуцдаг нь мөн л, тухайн субъектийн хувьд онцлог, давуу байдлаар тогтоосон нийгмийн баталгаа болно. Тухайлбал, эрүүл мэндийн даатгалаас бусад санд шимтгэл төлдөггүй тул даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход шимтгэл төлсөн хугацааг бус ажилласан хугацааг харгалздаг байна.

Цагдаагийн алба хаагч нь, төрийн жинхэнэ алба хаагч тул төрийн алба хаагчийн нийгмийн хамгааллын арга

хэмжээ холбогдох баталгаа нь түүнд мөн хамаарна.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 -д Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх зарчмыг сахиулах, нийгмийн хэв журмыг хамгаалахтай холбогдсон төрийн тусгай чиг үүрэгтэй алба хаагчид хамаарахыг, 8.1.4 ба 8.1.6-д цагдаагийн төв байгууллагын дарга, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын офицер, ахлагч төрийн тусгай алба хаагч болохыг¹⁴ тус тус хуульчлан бататгасан байна. Мөн хуулийн 27 дугаар зүйлд, төрийн албан хаагчийн баталгааг тусгайлан заасан бөгөөд эдгээрийн дотор нийгмийн хамгааллын баталгааг тогтоосон заалтууд цөөнгүй бий. Үүнд:

1.Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшил, тэтгэвэр, тэтгэмж авах

2.Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах

3.Гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг харгалзан, зохих журмын дагуу албаны унаа хэрэглэн, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн

¹⁴ www.legalinfo.mn

авах.

4.Төрөөс орон байраар хангагдах

5.Төрийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах.

6.Иргэний эрүүл мэндийн тухай хуульд заасан тухайн жилийн эмчилгээний төлбөрийн хэмжээнээс давсан хэсэг болон магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах

7.Гэр бүлээс нь их, дээд, мэргэжлийн сургуульд элссэн 1 хүүхдийнх нь сургалтын зардлыг төрийн дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуулийн тус тусын жишгээр тооцож, төр хариуцах зэрэг заалтууд нь төрийн жинхэнэ алба хаагчийн нийгмийн баталгааг тогтоосон хэрэг юм.

Иймд төрийн алба хаагчийн нийгмийн баталгаа нь, цагдаагийн алба хаагчид мөн адил хамаарагдана.

Төрийн жинхэнэ албан хаагчийн, нийгмийн нийтлэг баталгаанаас

гадна цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдалтай салшгүй уялдаа холбоотойгоор зөвхөн цагдаагийн алба хаагчид хамаарах нийгмийн тусгай баталгааг хуулиар тогтоодог.

Монгол Улсын "Цагдаагийн албаны тухай хууль"¹⁵-ийн 37, 38, 39 дүгээр зүйлд цагдаагийн алба хаагчийн, үүргээ биелүүлэх баталгааг тогтоосон байна. Албан үүргээ гүйцэтгэж байгаад хөдөлмөрийн чадвараа алдах, амь насаа алдах тохиолдолд цалин ба тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг олгох, түүнчлэн үзүүлэх тусламж хөнгөлөлтийн арга хэмжээг тодорхой заасан болно.

Иймд хууль сахиулах салбарын эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, зорилт, шаардлага үндсээрээ өөрчлөгдөж, үүнийг дагаад, цагдаагийн алба хаагчдын эрх зүйн болон нийгмийн баталгааг шинэ шатанд гаргаж, асуудлыг дорвитой судлах, хөндөх шаардлага бий болж байна гэж судлаачийн хувьд үзэж байна.

¹⁵ Төрийн мэдээлэл. 2013. №29



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ САХИУЛАХ
УНДГАЙН
УНДГАЙН
УНДГАЙН

**Уншиж танилцан нийтлэхийг зөвшөөрсөн:
Сэтгүүлийн зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор,
цагдаагийн хурандаа Ю.Бадамханд**